



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Түнэл сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ХӨА-2022/99/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Хөвсгөл аймаг

Мөрөн сум

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ

Утас: 88090438 Цахим хаяг: [baterdenee@audit.gov.mn](mailto:baterdenee@audit.gov.mn)

Ахлах аудитор: Д.Отгонбаяр

Утас: 89306788 Цахим хаяг: [Otgonbayarde@audit.gov.mn](mailto:Otgonbayarde@audit.gov.mn)

Төгс суурь стандарт Аудит ХХК-ийн

Ерөнхий захирал: Т.Батсайхан

Утас: 99010760 Цахим хаяг: [tcc.audit.mn@gmail.com](mailto:tcc.audit.mn@gmail.com)

Аудитын менежер: Г.Оюунгэрэл

Утас: 77551229 Цахим хаяг: [tcc.audit.mn@gmail.com](mailto:tcc.audit.mn@gmail.com)

Ахлах аудитор: Д.Алтайбаяр

Утас: 77551229 Цахим хаяг: [tcc.audit.mn@gmail.com](mailto:tcc.audit.mn@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1	Аудитын санал дүгнэлт.....	2
2.	Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	4
2.4	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6	Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3.	Аудитын тайлан.....	11
3.1	Ерөнхий зүйл.....	11
3.2	Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3	Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4	Материаллаг байдал .....	12
3.5	Санхүүгийн тайлангийн тодруулга .....	13
3.6	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7	Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	15
3.8	Аудитын гол асуудал .....	15
3.9	Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.9.1	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
3.10	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11	Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4.	Аудитын илрүүлэлт .....	16
4.1	Залруулсан алдаа .....	16
4.2	Төлбөрийн акт .....	16
4.3	Албан шаардлага .....	16
4.4	Зөвлөмж.....	16
5.	Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	18

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2022.02.25 № 01/2022  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТҮНЭЛ СУМЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА  
И.ӨЛЗИЙБАДРАХ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Түнэл сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Түнэл сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

*(Signature)* А.ЭРДЭНЭБААТАР



## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>110,855,060.79</b>	<b>232,679,580.79</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>00.00</b>	<b>17,568,815.00</b>
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>00.00</b>	<b>17,568,815.00</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	<b>00.00</b>	<b>17,568,815.00</b>
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	17,568,815.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>00.00</b>	<b>42,902,402.00</b>
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	00.00	42,323,200.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>00.00</b>	<b>579,202.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	00.00	579,202.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>110,855,060.79</b>	<b>172,208,363.79</b>
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>42,523,895.29</b>	<b>89,901,874.79</b>
35110	Тусгай зориулалттай материал	7,455,854.76	6,325,251.00
35130	Эм боох материал	35,068,040.53	83,576,623.79
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>66,320,485.50</b>	<b>80,295,809.00</b>
35410	Бичиг хэргийн материал	576,265.00	1,243,131.00
35420	Аж ахуйн материал	47,142,450.00	51,357,750.00
35440	Түлш, шатах тослох материал	2,034,900.00	00.00
35460	Хүнсний материал	5,551,350.50	7,579,288.00
35470	Бусад хангамжийн материал	11,015,520.00	20,115,640.00
35600	Мал амьтад	2,010,680.00	2,010,680.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,345,895,319.96</b>	<b>1,359,607,971.70</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,345,895,319.96</b>	<b>1,359,607,971.70</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,313,567,319.96</b>	<b>1,341,487,971.70</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,327,071,414.00	1,327,071,414.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-90,398,453.28	-113,623,213.20
39203	Авто-тээврийн хэрэгсэл	56,289,219.00	37,989,219.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-27,458,776.10	-13,510,312.58
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	83,050,947.00	102,388,656.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-51,987,684.68	-17,995,290.58
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	45,217,634.00	30,585,300.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-28,216,979.98	-11,417,800.94
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>32,328,000.00</b>	<b>18,120,000.00</b>
39301	Програм хангамж	15,792,000.00	792,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-792,000.00	00.00
39303	Бусад биет бус хөрөнгө	17,328,000.00	17,328,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,456,750,380.75</b>	<b>1,592,287,552.49</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,456,750,380.75</b>	<b>1,592,287,552.49</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,456,750,380.75</b>	<b>1,592,287,552.49</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	148,642,601.00	148,642,601.00
51101	Өмч: - төрийн	148,642,601.00	148,642,601.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,283,029,488.01</b>	<b>1,423,449,258.35</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,283,029,488.01	1,287,912,086.61
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	135,537,171.74
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	25,078,291.74	20,195,693.14
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,456,750,380.75</b>	<b>1,592,287,552.49</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
------------	----------	---------------------	-----------------------

<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>532,586,500.79</b>	<b>924,348,132.45</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>36,567,092.79</b>	<b>265,879,797.45</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>36,567,092.79</b>	<b>265,879,797.45</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,408,500.00	50,833,509.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	579,202.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	00.00	50,254,307.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	00.00	215,046,288.45
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>496,169,408.00</b>	<b>658,468,335.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	403,220,600.00	426,996,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>8,132,740.00</b>	<b>157,238,230.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	113,250.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,132,740.00	114,801,780.00
131106	Төсвийн урамшуулал	00.00	42,323,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>43,183,300.00</b>	<b>39,683,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	43,183,300.00	39,683,300.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>41,632,768.00</b>	<b>34,550,605.00</b>
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	41,632,768.00	34,550,605.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>508,570,800.33</b>	<b>592,515,254.11</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>508,570,800.33</b>	<b>592,515,254.11</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>507,022,325.33</b>	<b>590,329,019.11</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>318,487,307.00</b>	<b>359,363,501.00</b>
210101	Үндсэн цалин	318,487,307.00	325,628,059.00
210102	Нэмэгдэл	00.00	9,964,036.00
210104	Урамшуулал	00.00	23,771,406.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>42,912,576.00</b>	<b>47,216,348.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	29,926,335.00	32,785,918.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,247,783.00	4,950,872.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,598,227.00	2,614,964.00
210204	Ажилгүйдлийн даатгал	644,665.00	617,592.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,495,566.00	6,247,002.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>35,502,310.00</b>	<b>36,183,300.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,319,010.00	3,000,000.00
210302	Түлш, халаалт	31,903,000.00	31,903,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,280,300.00	1,280,300.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,409,056.00</b>	<b>31,676,424.00</b>
210401	Бичиг хэрэг	2,411,925.00	3,153,134.00
210402	Тээвэр, шатахуун	14,060,600.00	19,587,330.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,900,000.00	3,130,000.00
210404	Ном, хэвлэл	64,000.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,080,551.00	2,837,420.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,891,980.00	2,427,640.00

210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	540,900.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>32,164,811.80</b>	<b>60,972,273.47</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23,289,723.30	49,855,600.97
210502	Хоол, хүнс	7,225,088.50	11,116,672.50
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,650,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,576,000.00</b>	<b>3,964,603.76</b>
210604	Урсгал засвар	2,576,000.00	3,964,603.76
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,642,000.00</b>	<b>1,243,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,642,000.00	1,243,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,359,404.00</b>	<b>1,161,727.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,361,500.00	500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.00	400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	83,750.00	90,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	87,010.00	96,010.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	30,154.00	42,217.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	902,990.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>41,968,860.53</b>	<b>48,547,841.88</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,136,860.00	9,439,520.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,832,000.53	39,108,321.88
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,548,475.00</b>	<b>2,186,235.00</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>867,485.00</b>	<b>2,186,235.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	867,485.00	2,186,235.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>680,990.00</b>	<b>00.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	680,990.00	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>24,015,700.46</b>	<b>331,832,878.34</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>17,874,055.63</b>	<b>196,295,706.60</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	1,073,333.38
225002	Найдваргүй авлагын алдагдал	00.00	15,000,000.00
225003	Хөрөнгө оруулалтын гарз	00.00	180,222,373.22
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-17,874,055.63</b>	<b>-196,295,706.60</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>6,141,644.83</b>	<b>135,537,171.74</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	148,642,601.00	1,276,887,843.18	1,450,608,735.92
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	148,642,601.00	1,276,887,843.18	1,450,608,735.92
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	9,120,335.61	9,120,335.61
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	148,642,601.00	1,283,029,488.01	1,456,750,380.75
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	148,642,601.00	1,283,029,488.01	1,456,750,380.75
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	4,882,598.60	4,882,598.60
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	148,642,601.00	1,287,912,086.61	1,461,632,979.35

D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	-4,882,598.60
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	135,537,171.74	135,537,171.74
<b>D09</b>	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>148,642,601.00</b>	<b>1,423,449,258.35</b>	<b>1,592,287,552.49</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл	/төгрөг/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>496,019,408.00</b>	<b>616,145,135.00</b>	
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>496,019,408.00</b>	<b>616,145,135.00</b>	
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	403,220,600.00	426,996,200.00	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>7,982,740.00</b>	<b>114,915,030.00</b>	
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	684,000.00	113,250.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,298,740.00	114,801,780.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>43,183,300.00</b>	<b>39,683,300.00</b>	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	43,183,300.00	39,683,300.00	
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>41,632,768.00</b>	<b>34,550,605.00</b>	
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	41,632,768.00	34,550,605.00	
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>496,019,408.00</b>	<b>598,576,320.00</b>	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>496,019,408.00</b>	<b>598,576,320.00</b>	
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>494,470,933.00</b>	<b>596,390,085.00</b>	
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>318,487,307.00</b>	<b>359,363,501.00</b>	
210101	Үндсэн цалин	206,448,807.00	212,139,538.00	
210102	Нэмэгдэл	92,358,500.00	102,508,214.00	
210104	Урамшуулал	19,680,000.00	41,161,049.00	
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	3,554,700.00	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>42,883,938.00</b>	<b>47,216,348.00</b>	
210201	Тэтгэврийн даатгал	30,326,438.00	33,880,612.47	
210202	Тэтгэмжийн даатгал	3,139,400.00	3,562,255.39	
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,511,500.00	2,795,587.28	
210204	Ажилгүйдлийн даатгал	627,900.00	717,494.02	
210205	Эрүүл мэндийн даатгал	6,278,700.00	6,260,398.84	
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>35,502,310.00</b>	<b>36,183,300.00</b>	
210301	Гэрэл, цахилгаан	2,319,010.00	3,000,000.00	
210302	Түлш, халаалт	31,903,000.00	31,903,000.00	
210303	Цэвэр, бохир ус	1,280,300.00	1,280,300.00	
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>29,569,000.00</b>	<b>39,269,080.00</b>	
210401	Бичиг хэрэг	1,633,500.00	2,820,000.00	
210402	Тээвэр, шатахуун	16,095,500.00	17,552,430.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,900,000.00	3,130,000.00	
210404	Ном, хэвлэл	64,000.00	00.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,386,000.00	1,327,650.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,490,000.00	14,439,000.00	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>43,100,254.00</b>	<b>77,984,879.00</b>	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,052,254.00	63,540,269.00	
210502	Хоол, хүнс	11,048,000.00	13,144,610.00	

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.00	1,300,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,000,000.00</b>	<b>24,688,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	18,640,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	7,000,000.00	5,048,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,642,000.00</b>	<b>1,243,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,642,000.00	1,243,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,700,994.00</b>	<b>2,161,727.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,361,500.00	500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	850,000.00	400,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	83,750.00	90,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	87,010.00	96,010.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	33,000.00
210807	Газрын төлбөр	30,154.00	42,217.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,244,580.00	1,000,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>4,585,130.00</b>	<b>8,280,250.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,585,130.00	8,280,250.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,548,475.00</b>	<b>2,186,235.00</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>867,485.00</b>	<b>2,186,235.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	867,485.00	2,186,235.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>680,990.00</b>	<b>00.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	680,990.00	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>17,568,815.00</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-</b>	<b>17,568,815.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>17,568,815.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>				
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	509,014,800.0	501,230,105.0	7,784,695.0	98.5
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	509,014,800.0	501,230,105.0	7,784,695.0	98.5
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	509,014,800.0	499,043,870.0	9,970,930.0	98.0
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	332,187,400.0	329,455,794.0	2,731,606.0	99.2
210101	Үндсэн цалин	212,842,700.0	212,139,538.0	703,162.0	99.7
210102	Нэмэгдэл	97,790,000.0	95,899,600.0	1,890,400.0	98.1
210104	Урамшуулал	18,000,000.0	20,574,419.0	2,574,419.0	114.3
210105	Гэрээт ажлын хөлс	3,554,700.0	842,237.0	2,712,463.0	23.7
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	44,845,300.0	43,536,889.0	1,308,411.0	97.1

Түнэл сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	31,557,800.0	31,378,578.5	179,221.5	99.4
210202	Тэтгэмжийн даатгал	3,321,900.0	3,267,899.4	54,000.6	98.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,657,500.0	2,614,299.3	43,200.7	98.4
210204	Ажилгүйдлийн даатгал	664,400.0	604,428.0	59,972.0	91.0
210205	Эрүүл мэндийн даатгал	6,643,700.0	5,671,683.8	972,016.2	85.4
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>36,183,300.0</b>	<b>36,183,300.0</b>	<b>00.0</b>	<b>100.0</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,000,000.0	3,000,000.0	00.0	100.0
210302	Түлш, халаалт	31,903,000.0	31,903,000.0	00.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	1,280,300.0	1,280,300.0	00.0	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>25,683,000.0</b>	<b>25,010,650.0</b>	<b>672,350.0</b>	<b>97.4</b>
210401	Бичиг хэрэг	2,730,000.0	2,730,000.0	00.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	15,903,000.0	15,903,000.0	00.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,050,000.0	3,050,000.0	00.0	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.0	1,327,650.0	672,350.0	66.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,000,000.0	2,000,000.0	00.0	100.0
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>47,647,000.0</b>	<b>43,888,010.0</b>	<b>3,758,990.0</b>	<b>92.1</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	32,197,000.0	29,443,400.0	2,753,600.0	91.4
210502	Хоол, хүнс	13,450,000.0	13,144,610.0	305,390.0	97.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,000,000.0	1,300,000.0	700,000.0	65.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>11,700,000.0</b>	<b>11,700,000.0</b>	<b>00.0</b>	<b>100.0</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,200,000.0	7,200,000.0	00.0	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,000,000.0	1,000,000.0	00.0	100.0
210604	Урсгал засвар	3,500,000.0	3,500,000.0	00.0	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,100,000.0</b>	<b>847,000.0</b>	<b>253,000.0</b>	<b>77.0</b>
210702	Дотоод албан томилолт	1,100,000.0	847,000.0	253,000.0	77.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>2,457,400.0</b>	<b>2,161,727.0</b>	<b>295,673.0</b>	<b>88.0</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	500,000.0	500,000.0	00.0	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.0	400,000.0	00.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	300,000.0	90,500.0	209,500.0	30.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.0	96,010.0	3,990.0	96.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	87,400.0	33,000.0	54,400.0	37.8
210807	Газрын төлбөр	70,000.0	42,217.0	27,783.0	60.3
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,000,000.0	1,000,000.0	00.0	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,211,400.0</b>	<b>6,260,500.0</b>	<b>950,900.0</b>	<b>86.8</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,211,400.0	6,260,500.0	950,900.0	86.8
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>00.0</b>	<b>2,186,235.0</b>	<b>2,186,235.0</b>	<b>-</b>
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	00.0	2,186,235.0	2,186,235.0	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>509,014,800.0</b>	<b>501,230,105.0</b>	<b>7,784,695.0</b>	<b>98.5</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС</b>	<b>426,996,200.0</b>	<b>426,996,200.0</b>	<b>00.0</b>	<b>100.0</b>

	<b>САНХҮҮЖИХ</b>				
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	426,996,200.0	426,996,200.0	00.0	100.0
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	39,683,300.0	39,683,300.0	00.0	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	39,683,300.0	39,683,300.0	00.0	100.0
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	42,335,300.0	34,550,605.0	7,784,695.0	81.6
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	42,335,300.0	34,550,605.0	7,784,695.0	81.6
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	25.00	25.00	00.0	100.0
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	00.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	19.00	19.00	00.0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00	00.0	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>97,346,215.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>97,346,215.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>97,346,215.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>29,907,707.00</b>
210102	Нэмэгдэл	6,608,614.00
210104	Урамшуулал	20,586,630.00
210105	Гэрээт ажлын хөлс	2,712,463.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>3,679,459.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	2,502,034.00
210202	Тэтгэмжийн даатгал	294,356.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	181,288.00
210204	Ажилгүйдлийн даатгал	113,066.00
210205	Эрүүл мэндийн даатгал	588,715.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,258,430.00</b>
210401	Бичиг хэрэг	90,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,649,430.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	80,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,439,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>34,096,869.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	34,096,869.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>12,988,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,440,000.00
210604	Урсгал засвар	1,548,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>396,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	396,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,019,750.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,019,750.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>114,915,030.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>114,915,030.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	113,250.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	114,801,780.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	17,568,815.00

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Түнэл сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн хууль тогтоомжийн хэрэгжилт, анхан шатны баримт бүрдүүлэлтийг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Ахлах аудитор Д.Алтайбаяр, аудитор О.Оюунцэцэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Отгонбаяр, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар, Төгс суурь стандарт аудит ХХК-ийн чанарын хяналтын менежер Г.Оюунгэрэл, гүйцэтгэх захирал Т.Батсайхан нар хэрэгжүүлж, аудитын тайланг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор шалгагдагч байгууллагын удирдлагад гардуулна.

Түнэл сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төгс суурь стандарт аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөвсгөл аймгийн Түнэл сумын эрүүл мэндийн төв нь 2021 онд Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг эрхэмлэн дээдэлж, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг мэргэжлийн түвшинд хүртээмжтэй хүргэж, иргэн бүрд эрүүл зан үйлийг төлөвшүүлэн, эрүүл аж төрөх зорилго тавьсан байна.

Хөвсгөл аймгийн Түнэл сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эрт илрүүлэгчийн 12 үзлэг 5 сургалтыг 80%-д хүргэх
- Байгууллагын гадаад дотоод орчныг тохижуулан байгууллагын соёлыг төлөвшүүлэх
- Эмч мэргэжилтэн ажилтан бүр шинийг санаачлан хамт олноо манлайлан ажиллах
- Эмнэлгийн мэргэжилтнийг сургах мэргэжлийн ур чадвар хариуцлага ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлэх ойролцоо сумдын туршлага судлуулах
- Иргэдэд хүрч үйлчлэх сэтгэл ханамжийг дээшлүүлэх
- Хүн бүрийн сэтгэл шингэсэн оролцоо идэвхийг өрнүүлэх
- Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийг хангах
- Сүрьеэ өвчнийг эрт илрүүлж сүрьеэгүй сум болох
- Хүүхдэд ээлтэй эмнэлэг болох

2021 онд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- “Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан” 2021 оны 04 сарын 30-ны 67/А/268 дугаар тушаалаар Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг санхүүжүүлэх журам, тусламж үйлчилгээний багц, төлбөрийн хэмжээ батлах тухай
- “Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан” 2021 оны А/387/99 журамд нэмэлт оруулах, төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах тухай
- “Хөвсгөл аймгийн засаг даргын захирамж” 2021 оны А243 түр журам батлах тухай. Коронавируст халдвар (Ковид-19)-ыг илрүүлэх шинжилгээг төлбөртэй хийх түр журмаар баталсан байна.
- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ "12.7" хувьд өөрчлөлт орж "11.7" хувь, Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ "12.5" хувьд өөрчлөлт орж "11.5" хувь болж өөрчлөгдсөн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналтын нэгжийг шинэчлэн томилох тухай 2021 оны 11 сарын 09 өдрийн А/4 тушаалаар бүрэлдэхүүнийг шинэчилж 10 чиглэлээр ажлын төлөвлөгөөг баталжээ.

Дотоод хяналтын баг нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө гарган, улиралд нэг удаа хяналт хийж, тайланг удирдлагын багт танилцуулж шийдвэрлүүлдэг ба төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналыг баримтжуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түнэл сумын эрүүл мэндийн төвийн 2020 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн нийт зардал 509,0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 7.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80-хувиар буюу 6.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Түнэл сумын эрүүл мэндийн төвийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 135.5 сая төгрөгөөр буюу 9.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдлийг харуулав.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	00.00	17.57	17.57
Авлага	00.00	42.90	42.90
Бараа материал	110.86	172.21	61.4
Биет хөрөнгө	1,313.57	1,341.49	27.9
Биет бус хөрөнгө	32.33	18.12	-14.2
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,456.75</b>	<b>1,592.29</b>	<b>135.5</b>
Хуримтлагдсан үр дүн	1,283.03	1,423.45	140.4
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>1,456.75</b>	<b>1,592.29</b>	<b>135.5</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 17.6 сая төгрөг байна. Төрийн сангийн хэлтсээс татан төвлөрүүлэлгүй харилцах дансанд үлдээж баталгаажуулсан байна.

Авлагын үлдэгдэл 42.3 сая төгрөг байгаа нь Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс ковид цар тахлын үед иргэдэд үзүүлсэн цогц тусламж үйлчилгээнээс авах авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 61.4 сая төгрөгөөр өссөн. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан эм боох материал 63,5 сая,
- Эрүүл мэндийн газраас эрх шилжүүлэн авсан вакцин, эм тариа 166.0 сая
- Улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан түлш шатах тослох материал 19.5 сая,
- Сэлбэг хэрэгсэл 2.8 сая
- Бичиг хэрэг 3.1 сая
- Аж ахуйн материал 2.1 сая
- Тусгай зориулалтын материал 1.1 сая
- Хүнсний материал 11.1 сая төгрөг
- Бусад хангамжийн материал, 14.2 сая төгрөг
- 2021 онд иргэний хандиваар 1.8 сая төгрөгийн эм,эмнэлгийн хэрэгсэл тус тус зарцуулснаас шалтгаалжээ.

Биет хөрөнгийн үлдэгдэл 27.9 сая төгрөгөөр өссөн. Үүнд материаллаг нөлөөтэй биет хөрөнгө:

- Иргэний хандиваар авсан хүчилтөрөгчийн аппарат 1.1 сая төгрөг,
- Ашид буян ХХК-аас 15.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж,
- Пролианс ХХК-аас 14.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж,
- Төсвийн хөрөнгөөр 18.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдаж авсан.
- Орон нутгийн өмчийн газрын 2021 оны А/16 тушаалаар лабораторийн тоног төхөөрөмж 18.6 сая төгрөг,
- Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны А/148 -р тушаалаар дархлаажуулалтын хүйтэн хэлхээний тоног төхөөрөмж 4.7 сая төгрөг тус тус хүлээн авсан.
- 2021 онд Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2021 оны 18-р тогтоолоор 18.3 сая төгрөгийн авто тээврийн хэрэгслийг Аймгийн цагдаагийн газарт шилжүүлсэн.

- Түнэл сумын ИТХ-ын 2021 оны 37-р тогтоолоор 22 нэр төрлийн 11.3 сая төгрөгийн тавилга тоног төхөөрөмжийг акталж биет хөрөнгө данснаас хассан.
- Түнэл сумын ИТХ-ын 2021 оны 40-р тогтоолоор 38 нэр төрлийн 10.8 сая төгрөгийн тавилга эд хэрэгслийг акталж биет хөрөнгө данснаас хассан.
- 2021 онд Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2021 оны 110, 111-р тогтоолоор тоног төхөөрөмжийн 8.6 сая, тавилга хэрэгсэл 5.3 сая, программ хангамж 0.7 сая төгрөгийн дахин үнэлгээний үнийн зөрүүг орлогод хүлээн авч биет бус хөрөнгөд бүртгэсэн.
- Аймгийн ИТХ-ын 2021 оны 110, 111 дүгээр тогтоол, сумын ИТХ-ын 2021 оны 28 дугаар тогтоолоор тэг үлдэгдэлтэй тоног төхөөрөмжийн 8.6 сая, тавилга хэрэгсэл 5.3 сая, программ хангамж 0.7 сая төгрөгийн хөрөнгийг үнэлж орлого болгосон.

Биет бус хөрөнгө нь 14.2 сая төгрөгөөр буурсан нь аймгийн ИТХ-ын 109 дүгээр тогтоол, сумын ИТХ-ын 37 дугаар тогтоолоор 15.0 сая төгрөгийн өртөгтэй “Цахим эрүүл мэнд” программыг акталсантай холбоотой байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 509.0 сая төгрөгөөр, нийт зарлагыг 509.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсөв захирагч 2021 оны төсвийн төслийг бууруулан 509.0 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- Улсын төсвөөс 426.9 сая төгрөг,
- Орон нутгийн төсвөөс 39.7 сая төгрөг,
- Эрүүл мэндийн даатгалын сангаас 42.3 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөсөн.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх “Эмнэлгийн тусламж үйлчилгээ” хөтөлбөрийг нийт 501.2 сая төгрөгөөр хэрэгжүүлсэн.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллагад дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид 114.9 сая төгрөг хуваарилснаас эрүүл мэндийн даатгалын сангаас 114.9 сая төгрөгийг хуваарилсан.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 29.9 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 3.6 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 14.2 сая төгрөг, норматив зардалд 34.1 сая төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 13.0

сая төгрөг, дотоод албан томилолтод 0.04 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 2.0 сая төгрөг, нийт үлдэгдэл 17.5 сая төгрөг, нийт 97.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Нэмэлт төсвөөс 42.3 сая төгрөгийн авлагатай, тооцоо нийлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахал Монгол Улсад эрчимтэй тарсантай холбоотойгоор сумдын эрүүл мэндийн төвүүдийн 2021 оны дансны үлдэгдлийг Төрийн сангийн хэлтсээс харилцах дансанд үлдээж, баталгаажуулсан байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал. Үүнд: Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангасан байна.

Төсвийн тухай хуулийн 61 дугаар зүйлийн 61.2.-т “Энэ хуулийн 61.1.1-61.1.3, 61.1.5-61.1.7-д заасан төлөөлөн хэрэгжүүлэх чиг үүргийг энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан гэрээний үндсэн дээр улсын төсвөөс, 61.1.4-т заасан чиг үүргийг эрүүл мэндийн даатгалын сангаас олгох тусгай зориулалтын шилжүүлгээр тус тус санхүүжүүлнэ” заасан байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан тул санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Хөвсгөл аймгийн Түнэл сумын эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 213.1 сая төгрөгийн 67 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 213.1 сая төгрөгийн 67 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн ба хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Эрүүл мэндийн яамны сайдын 2019 оны А/540 дугаар тушаалаар сумдын хүн эмнэлгийг эрүүл мэндийн төв болгон өөрчилж тус тушаалаар дараах хүчингүй болсон байна. Үүнд: Эрүүл мэндийн сайдын Сум дундын эмнэлэг байгуулах тухай 2003 оны 114, Сумдын

эмнэлгийн статусыг өөрчлөх тухай 2011 оны 292, Сум дундын эмнэлэг байгуулах тухай 2013 оны 256 дугаар тушаалыг тус тус хүчингүй болгосон.

Үүнтэй холбогдуулан ЭМЯ-ны сайдын А/540 тушаалаар сумын эрүүл мэндийн төвийн зэрэглэл, бусад сумын хүн амын хамруулан тусламж, үйлчилгээ үзүүлэх зарим сумын эрүүл мэндийн төвийн үйлчлэх хүрээг тогтоох, багийн эмчийн салбар байгуулах, өөрчлөн зохион байгуулах журам гарсантай холбогдуулан сумдын хүн эмнэлгийг эрүүл мэндийн төв болгон өөрчилсөн байна. Улсын бүртгэлийн гэрчилгээ дээр Хөвсгөл аймгийн Түнэл сумын хүн эмнэлэг нэртэйгээр үйл ажиллагааг явуулж байгаа нь Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/540 дугаар тушаалтай нийцэхгүй байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын бүртгэл тайлагнал, шилэн дансны мэдээлэлттэй холбоотой 112.4 сая төгрөгийн 5 зөвлөмж өгсөн байна. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг дахин шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- Цахим эмнэлэг” программ хангамжийг Хөвсгөл аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 109 дугаар тогтоолоор акталсан.
- Үндсэн хөрөнгийн анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн үлдэгдэл өртөггүй болсон хөрөнгийг дахин үнэлж ашиглалтын хугацааг сунгах талаар, Хөвсгөл аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 111 дүгээр тогтоолоор шийдвэрлэсэн байна.
- Бараа материалын зарлагын гүйлгээг тайлант оны эхнээс сар сараар гаргаж хэвшсэн.
- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллээ бүрэн оруулсан байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

- Төрийн сангийн хэлтсээс татан төвлөрүүлээгүй харилцах дансны үлдэгдэл 17.6 сая төгрөг.
- Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтсээс ковид цар тахлын үед иргэдэд үзүүлсэн цогц тусламж үйлчилгээнээс авах авлага 42.3 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 19.1 сая төгрөгийн И-баримтгүй худалдан авалтын гүйлгээ хийгдсэн байна. Алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгсөн.

### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай асуудал илрээгүй тул залруулга хийгдээгүй болно.

### **4.2 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогоогүй.

### **4.3 Албан шаардлага**

Албан шаардлага хүргүүлээгүй.

### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

##### **1.1. Илрүүлэлт:**

Хөвсгөл аймгийн Түнэл сумын хүн эмнэлэг хуучин нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байгаа нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “хуулийн этгээдийн

мэдээлэлд орсон өөрчлөлт” оруулах, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалын 8 дугаар зүйлийн 8.1-т Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэхэд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийг баримтална” заасантай нийцэхгүй байна.

**1.2. Өгсөн зөвлөмж:**

Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-т “хуулийн этгээдийн мэдээлэлд орсон өөрчлөлт”-ийг хэрэгжүүлж ажиллах.

**2. Анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой.**

**2.1. Илрүүлэлт:**

И баримтгүй 19.1 сая төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Энэ нь үнэн зөв байдал, иж бүрэн байх, зэрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, 20 дугаар зүйлийн 20.1.4-д “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсвэл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Өгсөн зөвлөмж:**

Худалдан авалт, ажил үйлчилгээ тухай бүр И-баримтын дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтын бүрдлийг ханган ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөг/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Түнэл сумын эрүүл мэндийн төв	2	19.1			-	-	-	-	2	19.1